

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан Жолоочийн даатгалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.15 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “төгрөгөөр” гэсний дараа “, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан “Жолооч” гэснийг “Тээврийн хэрэгслийн өмчлөгч” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.15 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан “, эсхүл хуульд заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч, эсхүл “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч жолоочийн” гэснийг “жолоочийн хариуцлагын” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 17^{1.9} дэх хэсгийг нэмсүгэй:

“17^{1.9}. Энэ хуулийн 17^{1.1} дүгээр зүйлд заасан этгээд нь тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө уг тээврийн хэрэгслийг жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулна.”

2 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “хангуулсны” гэснийг “хангуулж, 17^{1.9}-д заасан даатгалд даатгуулсны” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг